

**2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН  
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

| № | Товч агуулга  | Хариуцах албан тушаалтан   |
|---|---|--|
| 1 | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжилтийн талаар дараагийн шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах. /НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Нутгийн захиргааны байгууллагууд/   | “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан ба энэ ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар Ашиг сонирхолын зөрчлөөс урьдачлан сэргийлэх сургалт, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтууд зохион байгуулж Нийл албан хаагчдаар Ёс зүйн мэдэгдэлд гарын үсэг зуруулан ажилласан.   |
| 2 | Монгол Улсын Засгийн газрын 100 хоног тохиохтой холбогдуулан нийслэлийн хэмжээнд 2017 оны 10 дугаар сараас гаргасан бодлого шийдлүүд, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрэх үр дүн болон тэдгээрийн шийдвэр арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр иргэдэд хүрэх ач холбогдол, үр өгөөжийн талаар мэдээллийг бэлтгэж тайлан хэлбээр 2017 оны 12 дугаар сарын 10-ны дотор НЗДТГ-ын холбогдох чиглэлийн хэлтсүүдэд ирүүлэх. /Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрууд/ | <p>Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/592, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/137,126 дугаар тушаалаар Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс зөвшөөрсөн бүсэд малтай өрхийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ерөнхий болон дэд ажлын хэсгийг байгуулан мал бүхий иргэдтэй дүүрэг бүрт уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Малаа худалдах хүсэлтэй иргэдийн малыг худалдан авах үнэлгээг тогтоох мэргэжлийн багаас бүрдсэн ажлын хэсгийг Ерөнхий менежерийн А/150 дугаар тушаалаар байгуулан жишиг үнийг тогтоож ажиллалаа. Зөвшөөрсөн бүсэд шилжин нүүх хүсэлтэй иргэд, худалдан борлуулах малын нарийвчилсан судалгаа, төсвийн тооцоог боловсруулан, уг ажилд зарцуулагдах санхүүжилтийг Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 сарын 16-ны өдрийн А/873 дугаар захирамжаар батлуулж шийдвэрлүүлсэн. Уг ажлыг гүйцэтгэхээр санал ирүүлсэн “Хүнс комплекс” ХХК-тай хамтран ажиллаж худалдан авах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар 112 өрхийн 4824 малыг хориглосон бүсээс зөвшөөрсөн бүсэд шилжүүлээд байна.</p> <p>Нийслэлийн суурьшлын бүсээс малыг бүрэн гаргаснаар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай боломж бүрдэнэ.</p> <p>Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Төрийн албан хаагч хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургатыг 10 сарын 29 өдөр “Авлигатай тэмцэх газар”-тай хамтран зохион байгуулсан.</p> |

|   |  |  |
|---|--|--|
|   |  | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сайжуулах чиглэлээр сургалт зохион байгуулж, байгууллагын бүх албан хаагчид ёс зүйн мэдэгдэлд гарын үсэг зурж баталгаажуулсан.   |
| 3 | Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын хороодод ажиллах хуваарийг батлах тухай” А/918 дугаар захирамжийн хэрэгжилтийг 2018 оноос эхлэн хангаж ажиллах. /НЗДТГ, Захирагчийн ажлын алба, Хэрэгжүүлэгч агентлагууд/ | НЗД-ын 2017 оны А/918 дугаар захирамжийн дагуу 2018 онд хуваарилагдсан хороодод ажиллах өдрүүдийг графикаар гаргасан. 2017 оны 12 дугаар сарын 12, 13, 14-ны өдрүүдэд газрын дарга, орлогч дарга, хэлтсийн дарга нар Сонигинохайрхан дүүргийн 21-р хороо, Баянзүрх дүүргийн 11,20-р хороо, Хан-уул дүүргийн 12, 13, 14-р хороодод тус тус ажиллаж НЗД-ын захирамжийг танилцуулсан. 2017 оны 12 дугаар сард хороодод ажилсан тухай тайланг НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэхээр ажиллаж байна |
| 4 | Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн жилд өр авлага үүсгэлгүй ажиллах, төсвийг зориулалтын зүйлд зарцуулах, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах. /Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд/   | Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын вэб хуудсанд санхүүгийн ил тод байдал гэсэн цэс үүсгэн, байгууллагын төсөв, санхүүгийн болон аудитын тайлан мэдээ, төсвийн гүйцэтгэлийг тухай бүрт нь оруулж байна. Мөн байгууллагын мэдээлийн самбарт санхүүгийн тайлан мэдээг сар бүр тогтмол шинэчлэн оруулж байна. 2017 онд хууль тогтоомжоор хориглосон ямар нэгэн үйл ажиллагааг явуулаагүй болно.   |

.....000.....